



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар A/339

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн 2019 оны хаваржилт хүндэрснээс мал олноор хорогдсон Богд суманд малын сэг зэм устгах арга хэмжээнд зориулан 2.000.000 сая (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийн тайланг 2019 оны 5 дугаар сарын 30-ний дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг тус сумын Засаг дарга (Ч.Чинзориг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

0111005.7